



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/60

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “А”, “Г” дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд боловсролын салбарын ариун цэврийн байгууламжийн дэлгэрэнгүй судалгаа гаргах, тулгамдаж буй асуудал болон ашиглалт, үйлчилгээний асуудлыг шийдвэрлэх, төслийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавих, тайлагнах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Дэлгэрсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Баярсүх -Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Э.Дөлбадрал - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Д.Эрдэнэчимэг -Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч

Б.Одхүү -Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч, Орчны эрүүл мэнд, халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн

Т.Бат-Өлзий -Боловсрол, соёл урлагийн газрын статистик хариуцсан мэргэжилтэн


Д.Нямдорж -Боловсрол, соёл урлагийн газрын хөрөнгө оруулалт, төсөв хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга:

Б.Даваадорж -Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн дарга

2.Аймгийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн ариун  
цэврийн байгууламжийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлж байгаа ажлын  
мэдээллийг Засаг даргын зөвлөлд сар бүр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн  
ахлагч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ